

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234723

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН АЛБАН ЁСНЫ ТӨРИЙН
БЭЛГЭДЛИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Д.Нямдорж

Хураангуй: Богд Хаант Монгол Улсын төрийн бэлгэдлийг бүтээхдээ Хүннү гүрний үеэс эх үүсгэлтэй монгол төрийн бэлгэдлийн уламжлал хийгээд эртний Энэтхэгээс үүдэл гаралтай хэмээдэг төрийн хос ёсны бэлгэдлийн уламжлалыг эвсүүлэн найрсуулж хэрэглэжээ.

Хуульд тусгагдсан байдлаар нь Монгол Улсын төрийн бэлгэдлийг дотор нь албан ёсны болон албан бус гэж хоёр ангилж болохоор байна. Албан ёсны бэлгэдэлд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т хуульчилж өгсөн төрийн сүлд, төрийн далбаа, төрийн тамга гэсэн гурван бэлгэ тэмдэг орж буй бол албан бус бэлгэдэлд хэдий хуульчлан батлаагүй ч хэрэглэж байсан төрийн дуулал, хаан төрийн долоон эрдэнэ зэрэг бэлгэ тэмдэг орно.

Монгол Улсын төрийн бэлгэдлийн онцлог бол шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт хааны эрх сүрийг өргөж, түүнээ бэлгэ тэмдэг бүрээр харуулахын зэрэгцээ үүндээ монгол төрийн уламжлал хийгээд эртний Энэтхэгийн төр, шашны бэлгэдлийг эвсүүлэн найрсуулж олон улсын жишгийг харгалзан тусгаж, ингэснээрээ тусгаар тогтносон, бүрэн эрхт улсыг байдлыг илтгэн харуулж байсанд оршино.

Түлхүүр үг: Занабазар, соёмбо, төрийн сүлд, төрийн далбаа, төрийн тамга

Богд хаант Монгол Улсын¹ төрийн бэлгэдлийг бүтээх ажил 1911 оны 12 дугаар

¹ Зүй нь “Монгол Улс” гэж бичих ёстой ч өнөөгийн нэршлээс ялгахын тулд энэхүү өгүүлэлд засаглалын хэлбэрээр нь тодотгож хэрэглэв. “Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс” (Нямбуу, 1993), “Олноо өргөгдсөн Монгол улс” (Бямбасүрэн, 2006) зэргээр бичсэн нь бий ч “Олноо өргөгдсөн” гэдэг нь хааны цол, оны нэр болохоос улсын цол биш юм. Үүнийг 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улс тусгаар тогтносноо Манжийн Засгийн газарт мэдэгдсэн бичиг”-т “...улсын цолыг Монгол хэмээн үе уламжлан...” (Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, 1982: 170), 1912 онд “Богд хаант Монгол Улсын Дотоод яамны сайдаас Дундад иргэн улсын Дотоод яаманд явуулсан цахилгаанд”-д “улсын нэрийг Монгол хэмээн нэрийдэж” (Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл: 1982: 171) гэж тус тус дурдсанаас болон 1911 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн “Монгол Улсын оны нэрийг “Олноо өргөгдсөн” хэмээх болсныг зарласан бичиг”-т “Мөнөөхөн Ерөнхийлөн шийтгэх газраас оны нэрийг “Олноо өргөгдсөний” хэмээн бичвээс болох, үл болох явдлыг зарлигийг гуйн айлтгасанд, ёсоор болгогтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж, энэ сарын есний өдрөөс эхлэн Олноо өргөгдсөний тэргүүн он хэмээн бичвээс зохих” (Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, 1982: 121) гэснээс тодорхой харж болно. Гэтэл “Богд Жибзундамба хутагт хаан ширээнд залраад, хишиг тараах анхны лүндэнгээрээ улсаа “Олноо өргөгдсөн Монгол улс” хэмээн цоллон нэрлэсэн байдаг” (Бямбасүрэн ба Гантулга, 2012, 197) гэж үзсэн нь “Шашныг мандуулах амьтныг жаргуулагч, Олноо өргөгдсөн Монгол Улсын эзэн шашин төрийг хослон баригч наран гэрэлт Богд хааны зарлиг” (Дэндэв, 2003: 125) гэсэн өгүүлбэрийн “Монгол Улсын” өмнөх “Олноо өргөгдсөн”-ийг улсын цол гэж ойлгосноос болжээ. Хэрэв тийм бол “Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч, Олноо өргөгдсөн Монгол Улс” гэгдэхэд хүрнэ. Гэтэл хишиг тараах зарлигийн энэ өгүүлбэр бүхэлдээ Богд хааны цол юм.

сарын 29-ний өдөр тулгар төрөө сэргээж, шарын шашны тэргүүн наймдугаар Богд Жавзандамба хутагт (1869-1924)-ыг шашин төрийг хослон баригч хаанд өргөмжилж, тусгаар тогтнолоо дэлхий дахинаа албан ёсоор тунхаглан зарлахаас өмнө эхэлжээ.

Энэ эрхэм чухаг ажлыг Сайн ноён хан Т.Намнансүрэн (1878-1919) тэргүүтэй монгол ноёдын идэвх санаачилга, наймдугаар Богд Жавзандамба хутагтын дэмжлэг, зарлигаар түүнд даншиг өргөх нэрийн дор 1911 оны зун Хүрээний Эрдэнэ шанзудбын тамгын газар “Манжийн “шинэ засгийн бодлого”-ыг хэрхэн эсэргүүцэх, Монголын тусгаар тогтнолыг хэрхэн сэргээх” (Батсайхан, 2014: 37) асуудлыг хэлэлцсэн Халхын дөрвөн аймгийн хан, ноёд, түшмэд, хутагт, хувилгаадын их чуулган болон тэднээс дөрвөн хан тэргүүтэй ноёд, лам нарын Богд уулын арын модонд гэр бариулан нууцаар хийсэн зөвлөгөөнөөс үндэс суурь нь тавигдсан ХХГБХТЕЗШГ² хариуцаж байсан байна.

Наймдугаар Богд Жавзандамба хутагтын зарлигаар, 1911 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр албан ёсоор ХХГБХТЕЗШГ хэмээн нэрлэж, түүний нэр заан тушаасны дагуу, даргаар нь Түшээт хан аймгийн чуулган дарга, засаг, улсын түшээ гүн Г.Чагдаржав, хамаарсан даргаар нь Сэцэн хан аймгийн хамаарсан жанжин, жүн ван Г.Гомбосүрэн, түр зөвлөн шийтгэх түшмэдээр нь Сэцэн хан аймгийн хамаарсан жанжин, засаг, хошууны бэйс Ц.Гомбосүрэн, Сайн ноён хан аймгийн жүн вангийн зэрэг, засаг, төрийн бэйл Г.Цэдэнсоном, Түшээт хан аймгийн гүнгийн зэрэг, засаг, тэргүүн зэрэг тайж М.Намсрай, Их Шавийн да лам Г.Цэрэнчимэд нарыг тус тус томилж, анх зургаан хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан тус газар үндсэндээ Түр засгийн газрын үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд ажиллах хугацаандаа Хаант Орос улсаас тусламж эрэх, Их Хүрээн дэх Манж Чин улсын амбан сайдыг хөөн явуулах, Монгол улсынхаа тусгаар тогтнолыг сэргээн тунхаглахад бэлтгэх зэрэг олон чухал ажил хийсний дунд төрийн сүлд, далбаа, тамганы эх загварыг гаргаж бүтээжээ.

Эдгээр төрийн бэлгэдлээс Манжийн амбан сайд Сандо-д зайлж гарахыг тулган шаардсан бичиг гардуулж, “Эдүгээ өмнө газар манж, хятад аймаг өвөр зуураа самууран Манжийн төрийг сөнөөхүйд хүрсэн чимээ олонд сонсогдох болсон, үүнд манай Монгол болбоос угтаа тусгай нэгэн улс мөн тул одоо хуучин журмаар өөрөө улс болон өөрийнхөө хэргийн эрхээ бусдаар эрхлүүлэхгүй шинэ төр байгуулан тогтоохоор зөвлөн тогтсон” (Сандаг, 1971: 139)-оо илэрхийлсэн тунхаг бичгийг ХХГБХТЕЗШГ-аас гаргасан 1911 оны 12 дугаар сарын нэгний өдөр Их Хүрээнд соёмбо сүлдэт далбааг мандуулсан (Сандаг, 1971: 252) бол наймдугаар Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч, наран гэрэлт, түмэн наст Богд хаанд өргөмжлөх их ёслолын үеэр тамга тэргүүтэй бэлгэдлийг бусад бэлэг сэлтийн хамт түүнд өргөсөн байна.

Чухам юу юу өргөснийг архивын эх сурвалжаас тодруулж үзвэл Богд хаанд хундага өргөхөд чин ван Ханддорж, гүн Намсрай, тамга өргөхөд да гүн Чагдаржав, өргөмжлөлд сайн ноён Намнансүрэн, жанжин бэйс Гомбосүрэн, мандалд Түшээт хан Дашням, Сэцэнхан Навааннэрин, бурханд хамба номун хан Пунцаг, дэд хамба Содномдаржаа, ном дор Манзушир хутагт Цэрэндорж,

² Үүнээс өмнө “Олон ван, бэйс, гүн, засаг, жич хамба, шанзудба, да лам нарын газар” (Батсайхан нар, 2018: 28) гэгдэж байжээ.

Жалханз хутагт Дамдинбазар, суваргад ноён номун хан Жигмэддорж, Эрдэнэ хамба Лувсанцэрэндагвадогми, долоон эрдэнийг Шанзодба Бадамдорж, мэргэн хамба Дэмбэрэлдаш, түмэн оны хангагчийг да жүн ван Гомбосүрэн, мэргэн ван Ананд Очир, ерөөл айлтгахад Да лам Цэрэнчимэд нар гүйцэтгэсэн ажээ³.

Богд хаан анхны зарлигаараа Монгол Улсын Засгийн газраа таван яамтайгаар байгуулснаа зарлаж, Гадаадын хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдаар чин ван Ханддоржийг, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдаар да лам Цэрэнчимэдийг, Цэргийн хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайдаар бэйс Гомбосүрэнг, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдаар түшээ гүн Чагдаржавыг, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдаар тайж Намсрайг тус тус тохоон томилж, маргааш нь буюу 1911 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Дотоод яамнаас “дээрээс шагнасан тамгыг хүлээн авч харьяат яамны хиур залж нээн хэрэг шийтгэх явдлыг”⁴ есөн газар тушаан мэдэгдсэний дагуу яамд, албан газрууд өөр өөрсдийн тамга, тугийг залж ёслон мөргөснөөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна⁵.

Улмаар Богд хааны зарлигаар 1915 оноос эхлэн тухайн үеийн Монголын сор болсон төрийн түшмэд, шашны зүтгэлтнүүд хамтран өөрийн төрийн хууль цаазын уламжлал болон дэлхий нийтийн хууль цаазын жишиг онцлогт тулгуурлан боловсруулж 1918 онд дуусган батлуулсан, 65 дэвтэр бүхий “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт”-т төрийн зарим бэлгэдлийг хуульчлан зааж өгчээ.

Богд хаант Монгол Улсын төрийн сүлд

Монгол Улсын төрийн сүлдээр анхдугаар Богд Жавзандамба хутагт Занабазар (1635-1723)-ын мутрын тэмдэг буюу эртний Энэтхэгийн ланз бичигт тулгуурлан 1686 онд зохиосон соёмбо бичгийн хуудас эхэлсний тэмдгийг⁶ сонгожээ. Энэ тэмдэг (**Зураг 1**)-ийг эрхэмлэн сонгосны учир нь анхдугаар Богд Жавзандамба хутагт соёмбо бичгийг зохиосны “Улс төрийн ач холбогдол гэвэл, Манжийн эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг үндэсний тусгаар тогтнол, өнө мөнхийн бие даасан байдлыг бэлгэдэж, шашин номын тухайд, тэр цагийн монгол бичгийн мэргэдийн хувьд номын гурван гэгээн хэл болж байсан монгол, самгард, төвөд хэлний үгийг бүрнээ тэмдэглэж чадахуйц бичгийн тогтолцоог буй болгосон” (Шагдарсүрэн, 2001: 129-130) гэх бөгөөд наймдугаар дүрийнх нь үед уг бэлгэдэл биеллээ олон Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, түүнийг шашин төрийг хослон баригч хаанаар өргөмжилсөнд хамаг учир оршино.

Ерөөс наймдугаар Богд Жавзандамба хутагтыг хаанд өргөмжлөхдөө “1. Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг удирдан манлайлагчийн нэг байсан, 2. Тэрбээр Монголын бурхан шашны тэргүүний хувьд тэртэй тэргүй сүсэгтэн олны

³ Үндэсний Төв Архив, ф. А3, д. 1, х. н. 2, 16 дахь тал.

⁴ Үндэсний Төв Архив, ф. А3, д. 1, х. н. 3, 38 дахь тал.

⁵ Мөн энэ өдөр Монгол Улсын оны нэрийг “Олноо өргөгдсөн” хэмээн цоллосон (Бадарч ба Дугарсүрэн, 2000: 61) байна.

⁶ Бярга буюу эгчимтэй адил үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр эхний буюу титэм үсэг ч гэдэг.

оюун санааны удирдагч байсан, 3. Чингис хааны удам – Өндөр гэгээний хойд дүр гэж өргөмжлөгдсөн учраас хэдийгээр төвөд хүн ч гэсэн алтан урагтай холбоотой хэмээн тооцогдож байсан, 4. Захирах шавь хамжлага, хөрөнгө чинээгээр Халхад хамгийн баян чинээлэг нь байсан, 5. Монголын нийгмийн бүх бүлэг, давхраа түүнийг тойрон хүрээлэхээс биш, эн зэрэгцэн хаан ширээ булаалдах ноёд төдий л байхгүй” (Болдбаатар, 2003: 162) зэргийг харгалзан үзсэнээс “Чингис хааны удам – Өндөр гэгээний хойд дүр гэж өргөмжлөгдсөн”-д ихээхэн ач холбогдол өгч байсан нь тухайн үеийн баримт бичгүүдэд тод үлджээ.

Тухайлбал, Хүрээнд сууж асан Манжийн амбан сайд Сандо-д зайлж гарахыг тулган шаардсан бичигт “Халх бүгдээр тахигласан ба бидний ноёдын өндөр өвөг Түшээт ханы хөвгүүн хэмээн өргөмжлөгдсөн хоёр ёсыг тохоолгон чадагч Жавзандамба ламыг хаанд өргөмжилж, тусгаар улс болохоор тогтоосон тул” (Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, 1982, 111) гэсэн бол наймдугаар Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаанд өргөмжлөхөд зууч түшмэлээс айлтгасан ерөөлд “манай Монгол Улсын эртний их Чингис хааны үрийн үр Түшээт ханы хөвгүүдээс дараалан шинж тэмдэг онц тодорхойгоор хувилж гурван цагийг илэрхийгээр заасаар өчнөөн зуун жилд Олноо өргөгдсөн шашныг мандуулах, амьтныг жаргуулагч аврал итгэл хамгийг айлдагч оройн чандмань эрдэнэ арга билгийг хосолж таалан зохиосон Очирдара гэтэлгэгч Богд гэгээнтнээ Монгол Улсын шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст Богд хаанд өргөмжлөн” (Батсайхан, 2014: 140-141) гэх зэргээр түүнийг Чингис хааны удам, анхдугаар Богд Жавзандамба хутагт, Өндөр гэгээн Занабазарын хойд дүр гэдгийг нь тодотгон бичиж, хэлдэг байснаа “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн гучин дөрөвдүгээр дэвтэр, “Лам нарын хэргийн хууль” дээдэд *“Жавзандамба ламыг өргөмжлөх нь: Нэгэн зүйл. Жавзандамба лам болбоос эртний Мин улсын цаг, Их Юан улсын Тайзу хааны үр, Халхын Очирбат Түшээт сайн ханы гэрт хувилгаан гарч бурхны шашныг дэлгэрүүлэн хамаг амьтныг тусалж халхын олон монголчуудыг тэргүүлэн авч манж монгол овогтныг найрамдуулан зохиож гайхамшигт явдлыг илэрхийлсэн учирт манж хаанаас Жавзандамба ламыг умард зүгийн амьтны итгэл номын богд хэмээн өргөмжилж алтан тамга, алтан навчит өргөмжлөлийн зэрэг зүйл бүрийн ёсны юм шагнаж лам эзэн нэгэн сууринд заларсан ба багш шүтээж ихэд өргөмжилсөн анхны төрлийн Өндөр богдоос эхлэн төрөл тутам сайн бэлгэ билиг лүгээ төгссөн шашныг мандуулах амьтныг жаргуулагч Жавзандамба ламд үе үеийн хэрэглэсэн олон зүйл ямба, цолын дээр аврал итгэл хамгийг айлдагч оройн чандмань очирдара хэмээн нэмэн өргөмжлөөд алтан тамга, алтан навчит өргөмжлөл олгуулсны тулд аливаа яамлаж төрийн хэрэг шийтгэхээс бус ном хурлын газар ба энгийн өдөр Жавзандамба ламыг хаанаас ахлуулж эрхэмлэн өргөмжлөгтүн”* (2018: 182) гэж хуульчилж өгсөн юм.

Ийм учраас анхдугаар Богд Жавзандамба хутагтын зохиосон соёмбо бичгийн хуудас эхэлсний тэмдэг буюу хожим мутрын тэмдгээ болгон хэрэглэж байсан эрхэм тэмдгийг түүний наймдугаар дүрийг шашин төрийг хослон баригч хаанд өргөмжилж тусгаар тогтнолоо сэргээсэн, Монгол Улсын төрийн сүлдээр сонгож, төрийн далбаа хийгээд тамгандаа залсан нь зүй ёсны, утга төгөлдөр хэрэг байжээ.

Өндөр гэгээн соёмбо тэмдгийг бүтээхдээ эртний Энэтхэгийн бэлгэдлийн ёгт ном “Нанживандан” (**Зураг 2**) үсгэн хээнээс эх авч, эртний монголчуудын сүлд нар, сар, гал болоод тамгануудын дүрсийг оролцуулан бүтээжээ. Түүний бэлгэдлийн тухайд тэмдэглэгдсэн эхний баримт 1911 оноос хойш, 1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуультай холбогдоно. Энэ Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үеэр төлөөлөгч Сэрээтэр “Соёмбо үсгийн утга нь юу, хэрхэх учир улсын тамга ба далбаанд энэхүү үсгийг оруулдаг вэ?” хэмээн асуусанд тухайн үеийн Ерөнхий сайд Б.Цэрэндорж “Соёмбо үсгийн тухай дэвтэр бичигт тайлбарласныг олж үзсэнгүй боловч, өвгөчүүдийн хэлэхийг сонсвоос урьд Өндөр гэгээн энэхүү үсгээр бүрэн эрхт Монгол улс хэмээн тэмдэглэсэн хэмээдэг бөлгөө”⁷ гэж хариулжээ.

Соёмбын судалгааг анх Ц.Дамдинсүрэн (1944; 2017), Б.Ринчен (1991; 2015), Х.Нямбуу (1979; 1993) тэргүүтэй манай судлаачид хийж, дүрсийнх нь бэлгэдлийг тайлбарлажээ. Тэдний тайлбарыг монгол тамганы дүрсийн бэлгэдлийг судалсан С.Дулам (2011a)-ын тайлбартай харьцуулж үзье.

Соёмбын дээрх галын дөлний дүрс: Соёмбын дээд оройд, нар, сарны дээр дүрсэлсэн гурван үзүүрт галын дөлийг Б.Ринчен эртний монголчууд галыг маш эрхэм болгож хүний уг удам залгамжлахын тэмдэг хэмээн гал голомт гэж хэлэлцдэг байсныг дурдаад уг дөл гурван үзүүртэйн учир нь “Монгол Улсын гал голомтыг өнгөрсөн, эдүгээ, ирээдүй гурван цагт буюу үүрд мандаж байх хэмээсэн утгатай тэмдэг” (2015: 390) гэжээ.

Харин Ц.Дамдинсүрэн “гал өөдөө бадардаг” гэсэн цэцэн үгийг оршил болгон монголчууд галыг “бадрах мандахын бэлгэ тэмдэг гэж үздэг” (2017: 229) гээд хүн төрөлхтөн гал хэрэглэх болсноос хойш гарсан их өөрчлөлттэй холбон ач холбогдлыг нь тодруулж бөө мөргөлийн нэгэн чухал шүтээн болохыг нь сануулжээ.

Тэгвэл Х.Нямбуу “соёмбын хамгийн дээр нь байдаг гурван үзүүртэй гал бол өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагт балчир, идэр, өтгөс гурван үеэрээ үүрд мандахын утгатай болно” (1979: 49) гээд галыг монголчууд мандаж бадрахын утгаар хэрэглэдэг заншилтай холбон тайлбарласан байна.

Монгол тамганы дүрслэлд үүнийг гурван гал чандмань тамга гэдэг. Сэцэн хан аймгийн То вангийн хошуунд хэрэглэж асан эл тамганы бэлгэдэл “гурван ертөнцийн гурван цагийн гал, үл бөхөх гал голомт” (Дулам, 2011a: 75) болно.

Мөн монгол домог зүйд “Урьд манай энэ тивийн хүн галгүй байж гэнэ. Тэгэхэд орой бүр огторгуй өөд харахад дээд тивийнхэн гал түлж, үй түмэн түүдгийн гал гялалзаж байдаг байжээ” (Ринчен, 1970: 35) гэсэн өгүүлэмж гарч буй нь эрт цагт монголчууд одыг гал хэмээн сэтгэдэг байсныг харуулж байна. Иймээс соёмбын орой дээрх галын дөлний дүрс нь мөн давхар оддын төлөөлөл дүр юм.

Соёмбын орой дахь нар, сарны дүрс: Соёмбын дээрх нар, сар, гал гурван дүрсний наран саран хоёр нь “Монгол Улс хэмээсэн тэмдэг” гэж Б.Ринчен үзээд монголчууд хоёр мянган жилийн тэртээ хятадтай харилцах захиа бичигтээ өөрсдийгөө нар, сар гаралтай хэмээж, тухайн цагтаа хараахан бичиг үсэгтэй болж амжаагүй байсан тул өөрийн улсыг нар, сараар дүрслэн тэмдэглэж байсныг дараах баримтаар өгүүлжээ.

⁷ Үндэсний Төв Архив, ф. 11, д. 1, х. н. 11, 70-71 дэх тал.

“Чи Еи Дун Гян Ган Муу бичигт Гүннийн (Хүннийн) Луушаан шаньюй хаан Христосын оноос өмнө 170-аад оны орчим буюу эдүгээгээс хоёр мянга гаруй жилийн өмнө хятадын Хуандайд бичиг бичихдээ биеийг тэнгэр газрын төрүүлсэн, наран саран мандуулсан Гүннийн (Хүннү гүрний) их шаньюй хаан гэж бичиж байсны зэрэг удаа буй. Энэ тухай орос хэл бээр лам Ехинфийн зохиосон Дундад азид байсан улсын түүх гэдэг зохиолын нэгдүгээр дэвтрийн 28-р хуудсанд товч тэмдэглэжээ” (Ринчен, 2015: 390).

Тэрээр цагааны зүгийн бөөгийн дуудлагад монгол улс ын гарлыг наран саран гаралтай гэж дууддаг ёс байдгийг дурдаж, монгол аймаг дотроо хандгай, хун шувуу, ууль шувуу, хөх бух, морин гэх зэргийг омог тус бүрийн гарлын тэмдэг болгож байсан ч нийтийн гарлын тэмдэг нь наран саран болохыг тодотгожээ.

Мөн өвгөд хуучид урьдын монголчууд малгай дээрээ улаан залаагаа зүүдэг нь наран, саран гаралтай улс гэснээ бэлгэдсэн хэрэг гэж хэлэлцдэг болоод VIII зууны хятад сударч Сы Ма Цяны “Ши Жи” хэмээх түүхийн тэмдэглэлд Хүннү улсын үед аян дайнд мордохдоо заавал саран эхийн дэлгэрч байгаа цагийг тохиолдуулан арван тавны өдөр морддог байжээ гэж өгүүлснийг тус тус тэмдэглэсэн байдаг.

Тэгвэл Ц.Дамдинсүрэн наран саран хоёрыг хүний амьдралд маш чухал ач холбогдолтой, хөх мөнх тэнгэрт үзэгдэх хамгийн гайхамшигт гэрэлт гараг мөн гээд тэднээр “хөх тэнгэрийг төлөөлүүлэн” (2017: 229) зурсан гэжээ. Түүний энэ санааг Х.Нямбуу дэмжиж “мөнх тэнгэрийг төлөөлөн” зурснаас гадна “эгнэгт батжин бэхжиж, энхэрч мөнхжихийн бэлгэдэл” (1979: 49) хэмээн үзээд гал, нар, сар гурав нийлээд “Монгол Улс үүрд бадран мандах болтугай” гэсэн утгатайг дурджээ.

Нарны дүрс нь дангаараа онгин тамга бөгөөд “эх дүрсийг үүтгэгч “нүднээс” зөвхөн гагц “цэцгий” (нүх) суулгамагц үүсэх анхдагч эх дүрсийн нэг” (Дулам, 2011а: 64) юм. Наран тамга гэдэг нэр томьёо Сэцэн хан аймгийн Боржигин Сэцэн вангийн хошууныханд түгээмэл. Онгин тамганы байгаль гарвалт анхдагч бэлгэдэл нь “нарны шүтлэг бэлгэдэл” (Дулам, 2011а: 70) юм. Хүннү нар наран, сарны шүтлэгтэй байсан тул онгин буюу наран тамгатай байх бүрэн үндэстэй.

Нар, сарны дүрс нь хамтдаа дан, давхар сартай онгин тамгадыг үүсгэх бөгөөд соёмбын сар нь давхар сар тул давхар сартай онгин тамга болж наран саран дүрсийн төлөөлөл бэлгэдэл болж (Дулам, 2011а: 67) байна.

Сарны дүрс нь доорх хэвтээ дөрвөлжин хамтаар дөрвөлжин дэвсгэртэй саран тамганы дүрс үүсгэж байна. Энэхүү тамга Сэцэн хан аймгийн Сан бэйсийн хошуунд хэрэглэгдэж байсан бөгөөд “наран сарны гэрэл гэгээ үл бөхөх, үл харанхуйлах” (Дулам, 2011а: 81)-ыг бэлгэддэг.

Сар дангаараа хөвчтэй саран тамга болно. Энэхүү тамгыг Сэцэн хан аймгийн Боржигон сэцэн вангийн хошуу, Хардэл жанжин гүн, Зоригт бэйс, Махасүг гүнгийн хошуу, Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуу, суурин жасаа, Засагт хан аймгийн хоёр илжгэн хошуу, Богдын их шавь нар тус тус хэрэглэж байсан бол одоо Баянхонгор, Увс аймгууд хэрэглэж байна. “Шинийн гурванаас эхлэн арвидаж буй хүрээ нь гэрэлтэгч, улам дүүрэхийн бэлгэт саран” (Дулам, 2011а: 80) тул арвидан дүүрэх, гэрэлтэн гийхийн бэлгэдэл тодорч байна.

Босоо дөрвөлжин хос дүрс: Соёмбын хоёр хажуугийн босоо дөрвөлжин дүрсийг Б.Ринчен “хэрэм” гэж үзээд бэлгэдэл утгыг нь “төрийн хүн ард дээр

доор, эр эмгүй сэтгэлээр эв нэгтэй болбоос монгол улс төмөр хэрэм мэт болно гэсэн санаа” (2015: 390) гэж тайлжээ.

Ц.Дамдинсүрэн “үг үсгийн байдлыг тэгш гоёмсог болгохоор хийсэн зураг байж болно” (2017, 229) гэж таамаглаад угаас гурвалжин, дөрвөлжин, дүгрэг гурав бол хэмжих ухааны үндсэн дүрс болохыг сануулжээ.

Харин Х.Нямбуу Б.Ринчений санааг дэмжиж “хэрмийг дүрсэлсэн тэмдэг” гээд “Монголын бүх ард түмэн эх орныхоо төлөө эв сэтгэл нэгтэй бол төмөр хэрмээс ч бат бэх гэсэн утга санааг хадгалжээ” (1979: 49) гэсэн байна.

Энэ дүрсийг монгол тамганд босоо дөрвөлжин (онгин) тамга гэдэг. Сэцэн хан аймгийн Хардэл жанжин гүний хошуу, То вангийн хошуу, Жонон гүн Цанлигдоржийн хошуу зэрэгт хэрэглэгдэж байсан эл тамганы бэлгэдэл нь “хэрэм”, “хана” (Дулам, 2011а: 47) гэсэн утгатай. Хэлбэр, агуулгын үүднээс энэ дүрсийн бэлгэдэл тохирч байна.

Гурвалжин хос дүрс: Соёмбын дотор дүрслэгдэж буй хөмөргөн гурвалжин дүрсийг Монголын эртний утга зохиол, ёс суртахуунтай холбож үзээд Б.Ринчен “дайсны өөдөөс хэрэглэх жад сумны хэлбэрийг дүрсэлсэн бөгөөд дайсныг дарах хэмээсэн утгатай” гээд дээр, доор хоёр газар байрласны учрыг “монголын хүн бүхэн их, бага, эр, эмгүй цөм нэгэн сэтгэлээр монголын тусгаар тогтнон мандахын, дайсныг хаанаас гарч ирснийг даран сөнөөхийн тэмдэг” (2015: 390) гэж тайлбарлажээ.

Мөн өвгөд хөгшдөөс сонсоход “дайсныг дарах, мууг сөнөөх хэмээсэн зүйл” гэж эрхэмлэж ирсэн хийгээд эртний Монголын хөшөө чулуу мэтийн дор энэ тэмдэг их буйг дурдсан байна. Үнэхээр ч энэ дүрс Рашаан хад, Хануйн Шивээт улаан, Баянцогтын Тоньюкукийн пайлуур, Бичигт улаан хад, Говь-Алтайн Цагаан голын хадны зурагт байдаг. Түүнчлэн Богдын их шавь нар болон харийнхнаас мажарууд ийм тамгатай юм.

Б.Ринчений тайлбарыг Х.Нямбуу дэмжиж “Гурвалжин дүрс бол жад сумны гилбэрийг дүрсэлсэн бөгөөд үзүүрийг доош хандуулсан нь улс ардын дайсныг дарна гэсэн далд утгатай” (1979: 49) гэжээ.

Тамгаар үзвэл соёмбын уруугаа харсан гурвалжин дүрс бол хөмөргөн гурвалжин буюу дормон тамга болно. Бэлгэдлийн хувьд “монгол бөө мөргөлд дан хараар будсан хөмөргөн гурвалжин хар тэнгэрийн язгуурыг тэмдэглэдэг” бол “Руни бичгийн “өрх”, “уурхай” “цооног” эсвэл “дайсныг егүүтгэх (зэв) болно” (Дулам, 2011а: 41-42) гэж үзжээ. Энд жад сумны гилбэр, дайсныг егүүтгэх зэв гэсэн бэлгэдлүүд үндсэндээ яв цав таарч байна.

Хэвтээ дөрвөлжин хос дүрс: Соёмбын доторх хөндлөн шулуун өнцөгтэй хоёр хэсэг дөрвөлжин дүрсийг Б.Ринчен “монголын хүн ард их бага, дээр дооргүй цөм улсынхаа төлөө шулуун шударгаар хүчээ өх хэрэгтэй хэмээсэн тэмдэг”, өнцөгтэй болгосон нь бөөрөнхийн эсрэг болгож “хүн бүхэн улсынхаа төлөө эрс шударга, өнцөгтэй шулуунаар зүтгэх хэмээсэн санаа” (2015: 229-230) гэж тайлбарлаад Монгол бичгийн угт түүх судрын зохиолд журамт эрсийн явдлыг өгүүлэхдээ явдал нь өнцөгтэй шулуун гэж гардгийг дурджээ. Энэ санааг Х.Нямбуу дэмжиж “шулуун шударга, бөх бат журамтай” гэсэн утгатай гээд дөрвөлжнийг харан “хуягийн ялтсыг дүрсэлсэн” (1979: 49) гэж үзжээ.

Харин тамганы дүрсийн үүднээс авч үзвэл Сэцэн хан аймгийн Сан бэйсийн хошуу, Зоригт бэйсийн хошуу, Сайн ноён хан аймгийн Заяын шавь нарын хэрэглэж

байсан хэвтээ дөрвөлжин (онгин) тамга болно. “Олбог”, “дэвсгэр”, “дэр” (Дулам, 2011а: 47) гэсэн утга илэрхийлж буй нь соёмбын бэлгэдлээс багахан зөрж байна.

Хос загасны дүрс: Соёмбын голд буй бие биеэ дагаж эргэсэн хос загасны дүрсийн бэлгэдлийг Б.Ринчен тайлбарлахдаа эртний монголчууд загасыг нүдээ аньдаггүй амьтан хэмээн маш сонор соргогийг дүрслэхэд хэрэглэдэг байсан гээд “хоёр загасыг зурсан арга билиг буюу эр эм хэмээсэн утгатай нь улсынхаа төлөө дээр, доор, эр, эмгүй цөм нэгэн сэтгэлээр арга билгийг хосолж, дайсны эсрэг нүд цавчилгүй сэрэмжилж бай хэмээсэн санаа” (Ринчен, 2015: 390) гэж үзжээ.

Тэрээр арга билгийн тухай ойлголт Хятадын зурхайд бас гардгийг дурдаад тэдний эртнээс уламжилсан заншилд загасыг дүрслэн зурахдаа Монголын нэгэн адил соргог сэрэмжтэйг дүрсэлсэн тэмдэг болгосоор ирж, үүнийхээ учрыг тайлбарласан нь хятад бичигт бүгд бий гээд ганц хятад гэлтгүй Европын толь бүхэн загасыг Хятадын утга зохиолд нүд үл цавчин ширтэх маш сэргэлэн болгоомжтойг дүрслэл болгодгийг тайлбарласан байдгийг өгүүлсэн байна. Харин Ц.Дамдинсүрэн “Дээр нь наран саран хоёр тэнгэрийг төлөөлөн байхад дунд нь бүх амьтны аймгийг төлөөлөн эр эм хоёр загасыг зуржээ” (2017: 229) гээд угаас дорно дахинд хамаг амьтан дотроос загасыг хамгийн үржилтэй амьтан гэж үздэг болохыг дурджээ.

Тэгвэл Х.Нямбуу Б.Ринчений тайлбарыг дэмжиж загасыг монголчууд өдөр шөнийн цагт нүдээ аньдаггүй, үр төл ихтэй амьтан гэж сонор соргог, өнөр өтгөнийг дүрслэхдээ хэрэглэдэг заншилтай гээд “энэ дүрс нь арга билиг буюу эр эм гэсэн утгатай дээр улсын хүн ард нь эрэгтэй, эмэгтэй ялгалгүй цөм сонор сэрэмжтэй байж, өсөж үржин улс орноо цэцэглүүл гэсэн утга агуулжээ” (1979: 49) гэсэн байна. Монгол тамганы дүрслэлд үүнийг нүдтэй загасан тамга гэх бөгөөд энэ тамгыг Өвөрлөгчид болон Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошууныхан хэрэглэж байжээ. Нүдтэй загасан тамга нь “арга билгийг тэгшид хослуулахуй, үрийн үргэлжид соргог, сэргэлэн байх” (Дулам, 2011а: 112)-ыг бэлгэддэг.

Дээрх судлаачдын тайлбараас үзвэл соёмбын орой дахь нар сарны дүрс нь Монгол Улс гэрэлтэн гийхийг, соёмбын орой дээрх галын дөлний дүрс нь Монгол Улсын гал голомт өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт балчир, идэр, өтгөс гурван үеэрээ үүрд мандан бадрахыг, соёмбын хажуугийн босоо хос дөрвөлжин дүрс нь Монгол Улсын хүн ард дээр доор, эр эмгүй эв нэгтэй, төмөр хэрэм бат бэх байхыг, соёмбын доторх хөмөргөн хос гурвалжин дүрс нь Монгол Улсын хүн ам их бага, эр эмгүй цөм нэгэн сэтгэлээр дотоод гадаадын дайснаа даран сөнөөхийн, соёмбын доторх хөндлөн шулуун өнцөгтэй хос дөрвөлжин дүрс нь Монгол Улсын хүн ард их бага, дээр дооргүй цөм улсынхаа төлөө шулуун шударга, бөх бат журамтай зүтгэхийг, соёмбын голд бие биеэ дагаж эргэж буй хоёр загасны дүрс нь Монгол Улсын хүн ам улсынхаа төлөө дээр доор, эр эмгүй цөм нэгэн сэтгэлээр арга билгийг хослуулж, сонор сэрэмжтэй байж, өсөж үржин улс орноо цэцэглэн хөгжүүлэхийг тус тус бэлгэджээ.

Үүнийг товчоор “Монголын ард түмэн гал мэт мандан бадарч, наран саран мэт гэрэлтэн мөнхжиж, сум мэт хурц шулуун, хуяг мэт бат бэх байж, загас мэт сонор соргог, өнөр өтгөн явж, арга бэлгээ хослон төмөр хэрэм лугаа адил төр улсаа хамгаалъя гэсэн гүн утгатай” (Нямбуу, 1979: 49) гэсэн нь ч байна.

Соёмбын дээрх “галын дөл, нар, сарнаас бусад нь ертөнцийг бэлгэдсэн утга бүхий нандин тарни” (Нямбуу, 1979: 43), “соёмбо нь ертөнцийн үүсэх уг сурвалж

хэмээн дорно дахины гүн ухаанд үздэг хий, гал, шороо, ус зэрэг язгуур махбодыг дор нь байрлуулж, сав ертөнцийн оршлыг бэлгэдсэн тэрхүү шороо, ус, гал, хийн дээр огторгуйг дүрслэн, басхүү шим ертөнц буюу хүний төрхийг тусгасан үсэг” (Нямбуу, 1993: 3-4) зэргээр соёмбын бэлгэдлийг олон янзаар тайлбарласнаас тарни мэт хураангуй, амин утга нь “бүрэн эрхт Монгол Улс”-ыг бэлгэддэг аж.

Тийм ч учраас “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн гучдугаар дэвтэрт аливаа тамгыг цутгахдаа “тамганы төв хэсэг цөм соёмбын эвам... сийлэгтүн” (2018: 174) гэж зааж өгсөн байдаг нь төрийн тамгыг хуульчлаад зогсохгүй түүн дээр сийлэх төрийн сүлдийг хуульчилж өгсөн хэрэг юм.

Монгол Улсын төрийн сүлдний харьцаа хэмжээг Р.Отгонбаатар Эрдэнэ зуу, Амарбаясгалан зэрэг хийдийн хуучин суварга зэргийн олон соёмбо, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын нутаг дахь, Улаан дүвчин Аюуш гуайн 200-аад жилийн өмнө бүтээсэн гурван өнгийн чулуун шигтгэмэл асар том соёмбо тэргүүтэнтэй тулгаж нягтлаад, ямар ч өргөнтэй үзгээр бичиж бүтээсэн соёмбын өндөр нь 14 хувь, өргөн нь зургаан хувь, гал нэг хувь, нар хоёр хувь, сар нэг хувь, гурвалжин хошоод хувь, хөндөл нэжгээд хувь, баясгалант орчил дөрвөн хувь, хос багана тус бүр нэг хувь, бүх дүрс тэмдэг хоорондоо шүргэн буй хэмжээгээр бүтээдэг заншилтай⁸ (2005: 325) болохыг тогтоожээ.

Богд хаант Монгол Улсын төрийн далбаа

Монголчуудын далбааны уламжлал өнө эртнийх бөгөөд одоогоор мэдэгдээд буй хамгийн эртний далбааны дүрсэлбэр хүрэл зэвсгийн үед хамаарна. Энэ бол Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг, Хар салаа голын хадны зураг “Морьтон баатар” (Монгол Алтайн чулуун шастир, 2016: 50-51) юм. Нэг гартаа хэнгэрэг мэт зүйл барьж, бүсэндээ бороохой юм уу, сум гэмээр зүйл зүүсэн морьтой хүн, түүний морийг хөтлөгч бороохой барьсан явган хүн хоёрын зургийг анх 1994 онд Монгол, Америк, Оросын археологичид нээжээ. Уг зургийн тухай Д.Цэвээндорж, Н.Батболд нар “уг морьтой хүнийг жирийн хүн биш, тухайн үеийн цэрэг байлдааны туг, дохио хэнгэргийг барьж яваа эрхэм хүндтэй үүрэг гүйцэтгэгч гэдгийг тодотгон харуулахын тулд зориуд гартаа бороохой мэт зэвсэг барьсан явган хүнээр хөтлүүлэн үзүүлж, түүний хүндэтгэлтэй болохыг илэрхийлсэн байна” (2003: 19) гэж үзсэн бол С.Дулам “туг, хэнгэрэг хоёр нэг үүрэгтэй, хам утга бэлгэдэлтэй хамтдаа явдаг, голдуу нэг хүн хоёуланг нь хамааран хадгалдаг, авч явдаг байсныг нуттай гэрчилж байгаагаараа сонин байна” (2014: 8) гэжээ.

Энэ хадны зургийн өгүүлэмж болон эдгээр судлаачийн тайлбарыг харьцуулж үзвэл хүрэл зэвсгийн үед монголчууд далбаа хэрэглэж байснаар зогсохгүй, түүнийг залах, хадгалахтай холбоотой зан үйл, ёс заншил хэдийн үүссэн байсныг харуулж байна. Мөн нэг гартаа барьсан далбааны ишинд амьтны арьс дэлгэсэн мэт байгаа нь монголчуудын өвөг дээдэс өнө эрт үед амьтны арьсыг модонд уяж далбаа хийж байсныг нотлох баримт болно (Цэвээндорж ба Батболд, 2003: 20).

Ингэж хийхдээ гол төлөв унаганы арьсыг толгой дөрвөн годтой, туурайтай битүү өвчин аваад модон ишинд гол нуруугаар нь сүвлэн тохож бөхөлдөг, түүнээ

⁸ Үүнийг хуучин монгол хэмжээгээр илэрхийлбэл соёмбыг хуруу өргөн үзгээр бүтээхэд өндөр нь 14 хуруу, өргөн нь зургаан хуруу болдог байна.

ташуухан шиг байрлалтайгаар бөхийлгөн босгож тогтоодог байжээ. Хөндлөнгөөс нь харахад дөрвөн хөл нь доош уншиж, сүүл толгой нь гол модон дээгүүр туушдаа бэхлэгдсэн сүр ихтэй сонин тийм далбааг монголчууд олон оны тэртээ хэрэглэж байжээ. Туурайтай дөрвөн гол нь доош уншиж их л сүртэй харагддаг тийм өвөрмөц дохио тэмдэг нь яван явсаар бөс даавуугаар солигджээ... Унаганы арьсаар хийсэн далбаа хорьдугаар зууны эхэн үе хүртэл хадгалагдаж байсан баримт бий. Чингисийн тугийн сүмүүдэд хар унаганы арьсыг туурайтай голтой нь авч нэг бол модон ишин дээр нуруугаар нь тохож бэхэлсэн, нэг бол хажуу тийш нь харуулан нөгөө талын хөлөөр нь ишнээс бэхэлсэн, тэр ч байтугай унаганы арьсыг тулам өвчиж толгой талаар нь тугийн ишинд углан дөрвөн тууртай хөл сүүлийг унжуулсан тийм далбаанууд байсан ажээ. Тэдгээрийн зарим нь Монгол нутгийн дөрвөн зүгт байгуулсан тугийн гэрт, дараа нь сүмд хадгалагдаж байжээ. Дорнод аймгийн Булган сумнаа байсан тугийн сүм, эсвэл Ханхөхий дэх тугчны отог зэрэгт бүхий тийм далбаа цагийн эрхээр үрэгдэж үгүй болсон (Түдэв, 2002: 5-6).

Далбаа нь дөрвөн шийр, толгой, сүүл мэтээс бүрдсэн унжлагатай болдгийг нь “гөхөл” (хөхөл) гэж нэрлэж байжээ. Есөн хөхөлтэй нь далбаа, есөн хөлтэй нь туг, гурван бүчтэй нь дарцаг, гурвалжин өнцөгтэй нь хиур (Түдэв, 1996: 33-34; Жамбалдорж, 2006: 126) болдог байна.

Монгол Алтайн уулсын оргил хэсгээс олдсон, хүрэл зэвсгийн үед хамаарах дээрх хадны зургийн дараах далбаатай холбоотой олдвор Хүннүгийн үед хамаарах бөгөөд Төв аймгийн Батсүмбэр сумын Ноён уулын Хүннүгийн язгууртны булшнаас Хүннүгийн торгон далбаа биет байдлаар олдсон (Руденко, 1962; Цэвээндорж ба Батболд, 2003: 20) бол умард Хүннүгийн Жижи шаньюй таван өнгийн тугтай байсан (Сүхбаатар, 1980: 68) тухай сурвалжийн мэдээ бий.

Үүнээс хойш монголчууд XIII-XIV зууны үед 44 хөх монголыг төлөөлсөн 44 хэлтэй, гурвалжин хөх дарцаг хэрэглэж байсны төв дунд нь язгуурын монголчуудын сүлд шүтээн болсон цагаан шонхор шувууг шунгаж буй байдлаар дүрсэлдэг байжээ. Мөнх хөх тэнгэрийг бэлгэдэж, өнө мөнх орших утгатай уг дарцгийн голд цагаан шонхор шувуунаас гадна нар, сарыг дүрсэлсэн нь ч бий. Өнгөөр нь энэхүү дарцгийг “Хөх Монголын хөх туг”⁹ (Нямбуу, 1990: 31) хэмээдэг.

1911 онд Монгол Улсын төрийн далбааг бүтээхдээ “Олон улсын дор цөм өөр өөрийн далбаа буй, бидний монгол болбоос өөрөө эзэрхэх эрх хэмжээ бүхий нь мөн тусгайлан далбаа байгуулж тусгаар эрх бүхийг илэрхийлбэл зохимой” (Нямбуу, 1979: 18) хэмээн онцгой ач холбогдол өгч, хэлбэр хэмжээ, өнгө зүс, дагалдах сүлд, үсэг бичгийг маш нарийн зааж өгчээ. Ингэснээр төрийн далбаа

⁹ Туг далбаа хоёр нь эрс тэс ялгаатай хоёр зүйлийн нэр байсан ч энэ үеэс энэ мэтээр хольж сольж, эндүү ташаа хэрэглэж эхэлсэн бололтой. Туг бол туг үснээс гаралтай, тайлга, тахилга, бишрэл хүндэтгэлийн бэлгэдэл учир гол төлөв адууны дэл сүүлний хялгасаар хийж сэрээ юм уу, наран саран титэмтэй ишнээ бөхөлсөн цэрэг дайны болоод төр ёсны бэлгэ тэмдэг болой. Далбаа бол хар унаганы юм уу, цагаан унаганы арьсыг битүү болон задгайлан өвчиж туурайт хөлийг унжуулан модон шилбэ ишинд бөхөлсөн цэрэг дайны болон төр ёсны бэлгэдэл юм. Цагийн урсгал, түүхийн эргүүлэгт туг далбаа хоёр аажмаар хувиран өөрчлөгдөж боловсронгуй болсоор иржээ. Туг нь аяндаа сүр сүлдийг илтгэх тал руугаа, далбаа нь төр улсыг бэлгэдэх тал руугаа хэлбийсээр амьтны арьс үс хялгаснаас бөс даавуу, алтан манжлага, саатай хөхөл болон өөрчлөгдөж бас өнгө, хэлбэр, дүрсийн бэлгэдлээр баяжсан ажээ (Түдэв, 2002: 7).

(Зураг 3) нь гурван ам¹⁰ буюу гурав нэгийг харьцах хэмжээтэй, босоо гонзгой дөрвөлжин хэлбэртэй, гол дэвсгэр нь шар өнгөтэй, ишний эсрэг талд гурван улаан хэлтэй, дээд хэлнээ “Ум”, дунд хэлнээ “Аа”, доод хэлнээ “Хум” маанийн үсэгтэй, хэлний этгээдээс бусад гурван талд ам хагас өргөн улаан хөвөөтэй, далбааны төвд, төр улс, хүн зоны үйлс бүтээх тусгай мөргөлийн ном бичсэн дэвсгэр дээр ариуны бэлгэдэл, хүрээтэй бадам бүхий соёмбо сүлд, “Э”, “Бам” үсэгтэй¹¹ бүтээгдсэн байна.

Соёмбын гал нь хөх, нар нь улаан, сар нь цагаан, дээд гурвалжин нь шар, хэвтээ дөрвөлжин нь хөх, дундах хос загасны өөдөө харсан нь улаан, уруу харсан нь цагаан, доод талын хэвтээ дөрвөлжин нь ногоон, гурвалжин нь улаан, хоёр хажуугийн босоо дөрвөлжин нь хар, хүрээний доторх дэвсгэр нь соёмбын доод талын хэвтээ дөрвөлжиний доод ирмэгээс дээш цэнхэр, доош цагаан, хүрээний бадам нь улаан, суурийн дэвсгэр нь хүрэн улаан, түүний доогуурх дэвсгэр нь хөх, цагаан, суурийн бадам нь улаан, шар ногоон, ногоон, шар хосолжээ.

Журамлан тогтоосноор төрийн далбааг жил бүрийн өвлийн сүүл сарын 30-наас цагаан сарын 15-ны өдөр өнгөртөл мандуулаад дотогш залах, мөн гадуур, дотуур хоёр майдар залах, аймаг шавийн тунсаг өргөх, их төр байгуулсан зун, өвлийн жахар тахил, цам бүжиглэх, хайлан өдрийн баяр, шинийн есний өдрүүдэд өглөө мандуулаад үдэш дотогш зална¹². Мөн Засгийн газраас төрийн далбааг албан газраас гадна айл өрх мандуулж болохыг зөвшөөрч, далбааны үсэг ном зэргийг бар сийлүүлэн дарж өгч байхыг тусгайлан зааж өгчээ. Хэмжээний хувьд төрийн ордон юм уу, томоохон албаны газар мандуулах далбаа нь хүрээтэйгээ 105х280 см, дэвсгэр нь 70х210 см, бага албан газар, энгийн айлд мандуулах нь хүрээтэйгээ 50х60 см, дэвсгэр нь 30х30 см байхаар тус тус журамлажээ.

Үүнээс гадна цэргийн далбааг тусад нь бүтээж, хорооноос дээших ангийн далбааг “туг”, түүнээс доошхыг дээрээс дараалуулан “далбаа”, “дарцаг”, “хиур” гэж нэрлэсэн байна. Энэ ёсоор Монгол Улсын цэргийн хамгийн том далбаа 280х240 см хэмжээтэй, 108 см манжлагатай, 56 см жадтай, 760 см иштэй, Цэргийн яамны туг юм¹³. Дэвсгэр нь шар, төвдөө төрийн сүлд болох гуутай соёмбо, “Э, Бам” үсэгтэй, хажуугаар нь монгол үсэгтэй тус тугийн жишгээр Халхын дөрвөн аймаг, Дөрвөдийн хоёр аймгийн цэргийг захирах жанжны тугийг дараах байдлаар бүтээсэн:

- Халхын Түшээт хан аймгийн цэргийг захирах жанжны туг нь цагаан дэвсгэр, хөх үсэгтэй.
- Халхын Сэцэн хан аймгийн цэргийг захирах жанжны туг шар дэвсгэр, хөх үсэгтэй.
- Халхын Засагт хан аймгийн цэргийг захирах жанжны туг улаан дэвсгэр, ногоон үсэгтэй.
- Халхын Сайн ноён хан аймгийн цэргийг захирах жанжны туг нь хөх дэвсгэр, цагаан үсэгтэй.

¹⁰ Нэг ам нь 70х70 см болно.

¹¹ “Э” нь билиг, “Бам” нь аргыг тус тус бэлгэддэг.

¹² Үндэсний Төв Архив, ф. АЗ, Д.1, х. н. 10, 52 дахь тал.

¹³ Манжлага нь хоёр тохой, хоёр ямх, дөрвөн хувь, жад нь нэг тохой, хоёр ямх, иш нь 15 тохой, гурван ямх (Нямбуу, 1993: 6).

- Дөрвөдийн Төгс хүлэг далай хан аймгийн цэргийг захирах жанжны туг хөвөөтэй, цагаан дэвсгэртэй.
- Дөрвөдийн Үнэн зоригт хан аймгийн цэргийг захирах жанжны туг нь хөвөөтэй, шар дэвсгэртэй.

Энэ тухай “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн зургаадугаар дэвтэр “Түшмэл байгуулах тушаал хууль”-д “Жанжин байгуулах нь: Нэгэн зүйл. Олон аймагт өөр өөрийн нэгжээд жанжин байгуулж уул аймгийн цэргийг захирга. Түшээт хан аймгийн жанжинд шулуун цагаан өнгөт туг нэг, Сэцэн хан аймгийн жанжинд шулуун шар өнгөт туг нэг, Засагт хан аймгийн жанжинд шулуун улаан өнгөт туг нэг, Сайн ноён хан аймгийн жанжинд шулуун хөх өнгөт туг нэг, Дөрвөдийн далай хан аймгийн жанжинд хөвөөт шар өнгөт туг нэгийг тус тус байгуул” (2018: 64) гэж зааж өгсөн байдаг.

Цэргийн туг, далбаа, дарцаг, хиурын бэлгэ тэмдэг, үг зэргийг мөн тогтоож өгчээ. Голын соёмбын гал нь хөх, нар нь улаан, сар нь цагаан, дээд гурвалжин нь хөх, гонзгой дөрвөлжин нь хүрэн, дундах загас нь улаан, цагаан, доод гурвалжин нь цагаан, дөрвөлжин нь ногоон байх ба суурийн дэвсгэр нь улаан, түүний доогуурх дэвсгэр нь хөх, цагаан, ногоон өнгийн дагнаас (судал) бүхий гадна дороо улаан өнгийн бадамтай, соёмбын дээд хүрээ нь хүрэн байна (Нямбуу, 1979: 22; 1993: 6).

Цэргийн далбааны төв дэх соёмбын хажуугаар байх үгийг цэргийн хороо, зуут, тавьт, аравт гэх ангийн дарааллаар эрэмбэлэн тогтоожээ. Хорооны туг “Монгол Улсын дэлхий дахины сүрийг бадруулагч цэргийн хорооны тэргүүн ангийн түшмэдийн туг” гэсэн үгтэй бол зуут нь “Монгол Улсын зуун цэргийг захирах түшмэдийн далбаа”, тавьт нь “Монгол цэргийн тавины даргын дарцаг”, аравт нь “Монгол Улсын цэргийн аравны цэргийн хиур” гэсэн үгтэй байдаг.

Далбааны төрлүүдээс цэргийн салбарт хэрэглэж байснаас гадна төр, шашны их жагсаалд хуульчлан хэрэглэж байжээ. “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн хорин тавдугаар дэвтэр, “Олон жагсаалын хууль” (2018: 157-158)-д энэ тухай дэлгэрэнгүй зааж өгсөн байдгаас Жавзандамба ламыг олон сүмд их ёсоор залрахад жагсаадаг их жагсаалын үед гүрмийн туг нэг, дэргэдийн их туг нэг, бага туг хоёр, их цагаан хиур нэг, төвөд цэнхэр хиур хоёр, найчун сахиулсны туг нэг, их шар хиур хошоод, төвөд хиур гурваад, харин дээрээс аливаа шинэлэх цагаалах түмэн өлзий гийсэн өдөр олон сүмд их ёслолоор залрах үед заларч гарах, ороход жагсаадаг төрийн жагсаалын үед Жавзандамба ламын их жагсаалд хэрэглэдэг туг, хиуруудыг хэвээр хэрэглэхээс гадна нэмж таван өнгөт хиурыг жагсаадаг байна.

Түүнчлэн ван, гүнгүүдийн жагсаал жагсаахдаа хан, чин, вангийн жагсаалд туг хоёр, хиур арав, жүн вангийн жагсаалд туг нэг, хиур найм, бэйлийн жагсаалд туг нэг, хиур зургаа, бэйс, улсын түшээ гүн, улсад туслагч гүн нарын жагсаалд тус тус хиур дөрвийг хэрэглэнэ. Олон яамны сайд, түшмэд улс төрийн ихээхэн хэргийн учир зарлигаар зарагдах үед тус тусын тушаал зэрэг дэвийг бодож жагсаал жагсаахдаа тэргүүн сайд, шадар сайд, бүрэн эрх барих сайд зэргийг бодохгүй, хан, чин вангийн жагсаалыг жагсааж, дэд сайд, туслах сайд бол жүн вангийн жагсаалыг жагсааж, эл жагсаалд хэрэглэдэг туг, хиуруудыг тоо ёсоор байлгадаг ажээ.

Богд хаант Монгол Улсын төрийн тамга

Монгол төрийн бэлгэдлийн анхдагч бэлгэ тэмдгийн нэг бол төрийн тамга юм. Хүннүгийн шаньюй нар хаш тамга барьж төрийн хэрэг шийтгэж байсан нь хятад сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн, Модунь болон түүний залгамжлагчдын Хан улсын хуандитай харилцаж асан бичиг захидлуудаас тодорхой байна. Учир нь эдгээр бичиг захидалд Хүннүгийн шаньюй нар төрийн тамга дарж баталгаажуулдаг байсан гэж судлаачид үздэг (Дэлгэржаргал ба Батсайхан, 2017: 182). МЭ 90 онд Умард Хүннүгийн шаньюйд төрийн хаш тамга байсан (Сүхбаатар, 1980: 56-57) сурвалжийн мэдээ бий бол IV зууны үед монгол угсааны Тоба улсын хаан хүрэн цацаг оосортой алтан тамга, VIII зууны үед Найман аймгийн тэргүүлэгч алтан тамга (Нямбуу, 1992: 69) тус тус барьж байжээ.

XIII зуунд Их Монгол Улсын хаан Чингис (1162-1227) “Мөнх тэнгэрийн хүчинд Их Монгол Улсын Далайн хааны зарлиг ил булга иргэнд хүрвээс биширтүгэй, аюутугай” гэх нэг мөр нь хоёроос гурван үгээс бүтсэн зургаан мөр монгол бичээстэй, 14.5x14.5 см хэмжээ (Өлзийдолгор, 1999: 18)-тэй, “Мөнх тэнгэрийн болон түүний газар дэлхий дээрх элч Далайн хааны таалал, зарлигийн гэрч бөгөөд бэлгэ тэмдэг” (Дулам, 2014: 119) болох хасбуу тамгатай байсан билээ.

Энэ тамгыг Чингис хаанаас Гүюг (1206-1248) хүртэлх хаад барьж байсан нь дамжиггүй ч Хубилай (1215-1294) хаан хэрхсэн нь тодорхойгүй юм. Тэрээр эртний Энэтхэг, Төвөдийн хаадын адилаар “Хоёр ёсыг тэгшээр явуулсугай” хэмээн бурхны шашныг улсын гол шашин болгож, Төвөд орноос Сажабандид Гунгаажанцаны ач Пагва лам Лодойжанцан (1235-1280)-г залан ирүүлж, өөрийн шадар, төрийн багшаар өргөмжилж, түүгээр дөрвөлжин бичиг 1260 онд зохиолгон улсын бичиг болгосон тул дөрвөлжин үсэгтэй хаш тамга хэрэглэсэн байх (Өлзийдолгор, 1999: 26) гэж үздэг. Учир нь энэ үеэс тамгыг дөрвөлжин үсгийн хичээнгүй тиг болон эвхмэл тигээр бичээслэх болж, төрийн дээд зэргийн хэрэгт хаш тамга, гурваас тавдугаар зэргийн хэрэгт алтан тамга тус тус дарах болжээ.

XV-XVI зууны үед Монголд төрийн “Их тамга”, “Алтан тамга” байсан (Нямбуу, 1992: 70) мэдээ байгаа ч олдсон биет баримт алга. Харин Манж Чин улс 1636 онд Өвөр Монголыг, 1691 онд Ар Монголыг, 1755 онд Баруун Монгол (Ойрад)-ыг тус тус захиргаандаа оруулснаар монгол ноёдод манж, монгол үсэг бүхий тамга бариулжээ. Мөн тэд анхдугаар Богд Жавзандамба хутагтыг 1723 онд жанч халснаас хойш түүний дүрүүдийг тодруулахад оролцох болж, хоёрдугаар Богд Жавзандамба (1724-1757)-аас хойших дүрүүдийг Төвөдөөс тодруулсан билээ. Ингээд наймдугаар Богд Жавзандамба хутагтыг 1875 онд өргөмжлөхдөө “Зарлигаар өргөмжилсөн шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Жавзандамба ламын тамга” гэсэн үсгийг монгол, манж, төвөд бичгээр гурван үе болгон бичсэн 5 кг алтан тамга гардуулжээ. Тамганы төвд манжаар бичсэн нь тэдний эзэн эрхийг илэрхийлсэн хэрэг юм. Дээр нь 1650 онд Далай ламаас Өндөр гэгээн Занабазарт хайрласан “Жавзандамба хутагт” цолыг тамганы бичээст хагасалж “хутагт”-ыг нь “лам” төдий болгожээ.

1911 онд монголчууд Манж Чин улсаас туурга тусгаарлахаар шийдэн эн

тэргүүнд Халхын дөрвөн аймгийн хан, ван, бэйл, бэйс гүн засаг чуулганы дарга, туслагч жанжин, хамба, шанзудба нарын тамгыг шинээр солих болсон учрыг мэдэгдэж Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас явуулсан бичигт “Тулгар төрийг нээж тогтоогоод тэргүүнд тамгыг олгуулах нь маш чухал. Зүй нь энэ жилд эрхгүй завдан гүйцэтгэвээс зохих тул саатасхийн саатуулах зэрэгт хүрүүлбээс үл болох явдлыг хамтаар ухуулан тушаасугай. Үүний тул өргөн илгээв” (Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, 1982: 113-114) хэмээсэн байдаг.

Наймдугаар Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаанд өргөмжлөх их ёслолын үеэр түүнд төрийн тамга өргөх хүндэт үүргийг да гүн Чагдаржав хүлээжээ. Чухам ямар тамга өргөсөн тухайд тэр үеэр хаанд зууч түшмэлээс айлтгасан ерөөлд “өлзийт зургийн тэмдэгт хаш эрдэнийн тамга” (Батсайхан, 2014: 140) гэж тодорхой дурдсан байдаг бол бусад эх сурвалжид “хасын тамга” (Магсаржав, 1994: 12) “хааны тамга” (Дэндэв, 2006: 88) гэх зэргээр хааны хаш тамга гэдгийг баталсан байдаг. Гэтэл Богд хааны хаш тамгыг бүтээсэн түүхийг нягталж үзвэл дээрх ёслолын үеэр энэ тамга бэлэн болоогүй байжээ. Учир нь ХХГБХТЕЗШГ-аас Монголын хаад эртнээс хаш тамга барьж төрийн хэргийг явуулдаг байсан уламжлалыг дагаж, Богд хаанд хаш тамга бариулахаар шийдэн, тохирох чулууг идэвхийлэн хайсаар 1912 оны өвөл Шавийн зайсан Цэнд гэгчийнхээс тохирох чулууг олжээ. Энэ тухай О.Намнандоржийн “Тайхамшигт бат бэх хаш чулуу” номд: *“Олноо өргөгдсөний хоёрдугаар оны өвөл Цэндийнд зайсан Содов улаагаар давхиж очоод хэлсэн нь: “Манай монголчууд өөртөө улс болж, Богдыг хаан өргөмжилж, эрдэнийн ширээнд залсан бөгөөд Хүрээний хэргийг ерөнхийлөн шийтгэх газраас хаан тамга сийлэх хаш эрдэнийн чулуу сураглахад, Цэнд чамд хаш мэт нэгэн хэсэг цагаан чулуу байсныг сонсоод томилогдон ирлээ. Хэрэв хэрэглэж болох бол үнэ хамаагүй хайрлахаар, эрдэнэ дайчин ван Ханддоржоос айлдсан” гэжээ*” (1955: 12-13) хэмээн чулууг олсон хугацааг болон түүгээр хийх тамганд ямар их ач холбогдол өгч байсныг тодорхой өгүүлж байна. Уг дөрвөлжиндүү хэлбэртэй, нэгэн хэсэг, аятайхан цагаан чулууг Цэнд зайсан дурдан буй үеэс даруй хорь шахам жилийн өмнө Сэцэн хан аймгийн Боржгин цэцэн чин вангийн хошууны нутаг Оцол Сансар орчмын Сүмбэр гэдэг уулын бэлээс олж, ихэд сонирхон, хаялгүй гэртээ авчирсанд харсан хүн бүхэн “Хаш мөн” гэдэг байжээ. Иймд тэр чулуугаа Хүрээнд авчирч эрдэнийн пүүст үзүүлтэл 100 лан хүртэл үнээр авъя гэсэн боловч заралгүй хадгалсан байжээ.

“Хааны тамгыг гадаад хүнээр хийлгэхгүй, өөрийн монгол хүнээр хийлгэж түүхэнд тэмдэглэнэ” (Намнандорж, 1955: 13) хэмээн Дотоод яамны тэргүүн сайд Цэрэнчимэд шийдсэн тул чулуучин хайсаар Зүүн Хүрээний Вангай аймгийн хар гарт Лувсангомбоор хийлгэхээр болжээ. Үүнээс үзэхэд Монгол Улсын хааны барих хаш тамгыг заавал монгол хүнээр хийлгэнэ гэж бэлгэшээл бодож байснаас гадна тамганы чулууг өөр улсаас захиалан авчирч болох атал, харь газрын чулуугаар биш, монгол газрын чулуугаар үйлдэнэ гэж шийдсэн байсныг харж болно.

Хар гарт Лувсангомбо Шарга морьтын аманд тусгайлан бариулсан улаан халзан гэрт тамгаа урлаж эхлээд, явц дунд Дотоод яамнаас гэрийг нь нүүлгэн Дунд голын хойд хөвөөнд ч буулгаж, тэр яамны баруун хамарт ч буулгаж, цэргийн харуул манаатай, нарийн чанд олон сар ажилласаар дуусгаад, тэргүүн

сайд Цэрэнчимэдэд хандан “Өнгөт наран гэрэлт Богд минь хаан суулаа. Өвгөн би түүний тамгыг өндөр уулын өвөрт эхлэн урлаж, өргөн голын захад үзэсгэлэнтэй сайхнаар үйлдэж төгсгөх, түмэн үеийн түүхт хэрэг” (Намнандорж, 1955: 13-14) гэж бэлгэшээн баярлаж байжээ. Энэ тамга (**Зураг 4**)-ыг тусгайлан ном уншиж ариутган аравнайлсан (Нямбуу, 1993: 9-10) гэдэг. Лувсангомбын гавьяа зүтгэлийг Богд хаан үүнээс хойш жил гаруйн дараа үнэлж сар бүр 30 төгрөгийн цалин олгож байхаар зарлиг буулгажээ. Богд хаанд төрийн тэргүүний хувьд дээрх хаш болон мөнгөн тамга (**Зураг 5**)-ыг, шашны тэргүүний хувьд алтан тамга (**Зураг 6**) тус тус бариулсан байна.

Эдгээрээс хаш тамгыг 1912 онд бүтээж өргөсөн бол 1911 онд хаан өргөмжлөгдөхөд нь мөнгөн тамгыг өргөсөн аж. Үүнийг мөнгөн тамган дээрх, бариулын баруун, зүүн этгээдэд хуваан бичсэн “Цагаагчин гахай жилд бүгдээр өргөмжлөн өргөв” гэсэн бичиг давхар гэрчилнэ. Харин алтан тамгыг хожуу, 1915 онд бүтээж өргөжээ.

Монгол Улсын хааны тамганы хэв загвар, эрхэмжлэл зэргийг “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн гучдугаар дэвтэрт “Хааны тэмдэг, хааны эрдэнэ тамгыг дарж хэрэглэх нь: Нэгэн зүйл. Шашин төрийг хослон мандуулагч, наран гэрэлт түмэн наст Богд хааны хас эрдэнэ тамга нэг, мөнгөн эрдэнэ тамга нэг. Үүнийг аливаа тархаах зарлиг, хэлтрүүлэх зарлиг, ухуулах, сургах, өргөмжлөл, жуух шар торгоны бичигт дарж хэрэглэнэ” (2018: 171) гэсэн бол мөн эл дэвтэрт “Жавзандамба ламын алтан тамга. Олон хутагт нарын тамга, жуухын тогтоосон хууль: Нэгэн зүйл. Шашныг мандуулагч амьтныг жаргуулагч, аврал итгэл, хамгийг айлдагч оройн чандмань очир дара Жавзандамба ламын тамга нэгийг цутган өргөж, хичээнгүйлэн болгоомжилж эрхэмлэн хадгалуул. Хаан эзэнд айлтгах бичиг ба лам нарт олгуулах гашог шар торгоны бичигт дарж хэрэглэгтүн” (2018: 171) гэж тус тус нарийн тодорхой зааж өгсөн байдаг.

Богд хааны хас эрдэнэ буюу хаш тамга бол зарлигт дардаг, хааны нэгдүгээр тамга юм. Жин нь 5 кг, хэмжээ нь 8.5х8.5 см тус тамганд “Шашин төрийг хослон баригч, наран гэрэлт Богд хааны тамга” (**Зураг 7**) хэмээх үгсийг соёмбо, монгол, дөрвөлжин гурван үсгээр бичжээ. Үүнээс соёмбо бичээс нь гурван эгнээ, найман мөр бол бусад бичээс нь тус бүр хоёр мөр юм. Зүүн дээд булан буюу соёмбо бичээсний эхэнд бярга буюу Өндөр гэгээний мутрын тэмдэг, улсын шинэ сүлдийг байрлуулж, найман мөр соёмбо бичгээр түүний наймдугаар дүр хаан сэнтийд заларч, Монгол Улс тусгаар болсныг, тамганы төвд, манж бичгийн оронд монгол бичгээр бичсэн нь төрийн эрхээ монголчууд өөрсдөө мэдэх болсныг, дөрвөлжин бичгээр тамга баригч Богд хаан нь Хубилай хааны адил төр, шашны хэргийг хослон барьж буйг тус тус бэлгэджээ.

Тамганы бариулыг хаан төрийн долоон эрдэнийн нэг, зэндмэнийн хэлбэртэй урласан нь монголчуудын юу санасан есөн цагаан хүсэл цаг үргэлжид сэтгэлчлэн бүтэж, элгээрээ энх амгалан, төрлөөрөө түвшин амгалан амьдрахыг бэлгэддэг. Улных нь зузааны дээд талд “Тэнгэр”, доод талд нь “Газар” гэсэн үгсийг сийлсэн нь тамга дарахад үсгийн толгой хааш харж буйг алдалгүй мэдүүлдэг байна.

Мөнгөн эрдэнэ буюу мөнгөн тамга нь цалин мөнгөөр хийгдсэн, бичээс нь хаш тамгатайгаа адилхан юм (**Зураг 8**). Хэмжээний хувьд мөнгөн тамга нь хаш тамганаасаа 1.5 см-ээр илүү, 5.890 кг жинтэй, бариул нь арслангийн дүртэй.

Тамганы зүүн хажуу талд “шашин маш тунгалаг”, баруун хажуу талд “төр маш бат” гэж монгол бичгээр бичсэн нь монголчуудын шүтэн биширч буй Бурханы шашин ариун тунгалаг, өргөн дээдэлж буй төр үргэлжид бат байхыг тус тус бэлгэдэн ерөөсөн хэрэг юм. Мөн тамганы дээд хажууд “тэнгэр”, доод хажууд “дэлхий” хэмээсэн нь тамга дарахад бичээсний толгой хааш харж буйг заахаас гадна дээд хэсэгт, эдгээр үгсийн харалдаа, бариулын хажууд буй “энх”, “түвшин” гэсэн үгстэй нийлж “тэнгэр энх”, “дэлхий түвшин” гэх гүн утга санааг илэрхийлж байна.

Тамганы дээр, бариулын зүүн, баруун этгээдэд “Цагаагчин гахай жилд бүгдээр өргөмжлөн өргөв” гэсэн нь уг тамгыг хэзээ үйлдэн Богд хаанд өргөснийг хэлж буйгаас гадна тамга баригчийг хэзээ хаан ширээнд залсныг давхар илтгэдэг. Энэ бичээс тамганы дээр, бариулын өмнөд, умард этгээдэд буй “энх”, “түвшин” гэх үгстэй нийлж “Цагаагчин гахай жилд энх түвшин бүгдээр өргөмжлөн өргөв” гэсэн утгын нийлэмж үүсгэх ажээ.

Харин Жавзандамба ламын алтан тамга нь 10.3х10.3 см хэмжээтэй, 6 кг орчим жинтэй юм. Дархан Барайшир гүнгийн урласан эл тамганы төвд тусгаар тогтносон Монгол Улсын бэлгэдэл, төрийн сүлд соёмбыг байрлуулж, “Зарлигаар өргөмжилсөн шашныг мандуулагч, амьтныг жаргуулагч, аврал итгэл хамгийг айлтгагч оройн чандмань очир дара ламын тамга” (**Зураг 9**) гэсэн үгсийг зүүн талд нь монгол бичгээр, баруун талд нь төвөд бичгээр тус тус сийлжээ. Энэ нь төр, шашин хоёрын язгуурыг бэлгэдэн хүндэтгэсэн хэрэг болно.

Бичээсний хувьд наймдугаар Богд Жавзандамба хутагтад 1875 онд Манжийн хаанаас шагнасан алтан тамган дээрх “Зарлигаар өргөмжилсөн, шашныг мандуулах, амьтныг жаргуулагч” гэсэн цолыг 1911 онд Монгол Улсын хаан сэнтийд залрахад нь монголчуудаас өргөсөн цолтой нийлүүлэн бичжээ.

Тамганы төвд сийлсэн сүлдний тухайд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн гучдугаар дэвтрийн “Аливаа тамга цутгах нь” гэсэн зүйлд буй “Тамганы төв хэсэгт цөм соёмбын э-бам” (2018: 174) сийлнэ гэж заасныг дагасан мэт боловч үргэлжлүүлээд “зүүн баруун этгээдэд монгол үсэг сийлэгтүн” гэснээс үзэхэд энэ заалт Богд хааны тамгануудтай огт хамаагүй, “аливаа тамга” гэдэг нь хааны тамганаас бусад тамга гэсэн утга илэрхийлж байсан нь тодорхой байна.

Учир нь энэ хууль зүйлийн бичигт аливаа тамга цутгахад олон яам, сайд, хан, хамба номун хан, эрдэнэ шанзудба, чуулганы дарга, жанжин, олон хутагт, их шавийн ван, гүн лам нарын тамгыг ерэн лан мөнгөөр цутгаж, дөрвөлжин тийш гурван ямх, дөрвөн пүн, зузаан тийш найман пүн, бариулд таван яамны тамга бол дөрвөн үзүүрт чандмань, бусдад цөм гурван үзүүрт чандмань, бариулын өндөр тийш гурван ямх, олон засаг хутагтын шавь нарыг захирах тамгыг тус бүр наян лан мөнгөөр цутгаж, дөрвөлжин тийш гурван ямх, гурван пүн, зузаан тийш зургаан пүн, бариулд хос эрдэнэ, бариулын өндөр тийш хоёр ямх, дөрвөн пүн, тамганы төв хэсэг цөм соёмбын эвам, зүүн, барууны этгээдэд монгол үсэг сийлж, үсгийн журмыг Дотоод яамнаас тогтоож айлтгаад зарлиг буулгасны дараа тамга цутгах газарт тушааж цутган үйлдүүлж байхаар тус тус тогтоосон нь “Шашин төрийг хослон өрнүүлэгч улсын эх дагинын тамга” болон Засгийн газрын таван яамны тэргүүн сайд нарт бариулсан яамны тамганаас эхлээд дооших бүх шатанд хэрэгжжээ.

Үүнд Дотоод яаманд “Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамга”, Гадаад яаманд “Гадаадын хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тамга”, Цэргийн яаманд Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамга”, Сангийн яаманд “Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамга”, Шүүх яаманд “Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамга” гэсэн монгол бичигтэй, төвдөө улсын сүлд-соёмботой тамга нэжгээдийг дээрх маягаар цутган олгосон байдаг.

Мөн аливаа тамгыг хүлээж авах, халж олгуулах журмыг “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т зааж өгсөн байдаг. Хүлээж авахдаа “Аливаа шинэ тамгыг тамгыг цутгаж төгсөөд Дотоод яам байцаан үзсэний хойно дансанд тэмдэглэж, уул тамга барих хүн Нийслэлд буй аваас биед тушаан ав. Хэрэв нутагт суусан болбоос бичиг явуулаад түшмэл гарч төлөө хүлээн ав. Хүлээж авсан нээж хэрэглэсэн өдрийг Дотоод яаманд мэдүүлгээр ирж байцаахад бэлтгэгтүн” (2018: 175) гэсэн бол халж олгуулахдаа “Аливаа тамганы үсгийг халж олгуулбаас зохих эсвээс он удаж үсэг балархай болбоос зарлигийг гуйн айлтгаад халж олгуул. Хуучин тамгыг битүүмжлэн Дотоод яаманд хүргэж ирүүлээд санд хураалгагтун” (2018: 175) гэжээ.

Түүнчлэн төрийн тамгыг эвдэх, гээсэн тохиолдолд хүнд гэмтэйд үзэж ял хэлэлцдэг байв. Богдын тамгыг алдах, гээсэн тохиолдолд тухайн хүнийг 35 өдөр дөнгөлж, 90 ташуур занчихаар хуульчилжээ. Харин алдаж, гээсэн тамга 30 өдрийн дотор олдох, эсвэл гал, ус, хулгайд алдаж эвдэрсэн нь илэрхий болбол ялаас хэлтрүүлнэ.

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн есдүгээр дэвтэрт “Тамга дарахад тасалдуулах нь” гэсэн тусдаа зүйл бий. Үүнд *“Аливаа олон яамны явуулан илгээх бичигт тамга дарахыг тасалдуулбаас харьяат бичээч эрхэлж илгээсэн хүнийг аливааг жаран ташуур занч. Бүрнээ тамга дарсангүй болбоос аливааг наян ташуур занч. Хэрэв тасалдуулж тамга дарсангүй буй жич бүрнээ тамга дарсангүй албаны бичиг цэрэг, морь дайчлах, хязгаарын газрын цэргийн хэрэглэлд нийлүүлэн өгөх амуу цалинд холбогдох болбоос аливааг зуун ташуур занч. Тэр тасалдуулсан тамга дарсангүйд харьяат яам сэжиглэж даруй дайчлан илгээхгүй нийлүүлэн өгөхгүй учирт цэргийн тухайг алдах, саад хийлгүүлэх болбоос буудан алагтун. Гянданд хорьж хүлээ, эрхэлж тамга дарах хүнийг тэргүүн болго. Тэргүүлсэн түшмэл нийлүүлэн үзэх хүнийг зуун ташуур жанчиж жаран өдөр дөнгө дөнгөлөхөд зогс. Хэрэв тамгыг тэрслүү дарваас тамга тасалдуулсан цаазын бичгийн ёсоор жаран ташуур занчигтун”* (2018: 80) хэмээн тамга дарахад тасалдуулах юм уу, дараагүй, буруу дарсан тохиолдолд тухайн хүнийг 60-100 хүртэл ташуур жанчиж, үр дагавраас нь хамааруулж гянданд хорих, буудан хороох хүртэл ял оноохоор заажээ.

Дүгнэлт

Монгол Улсын төрийн бэлгэдлийг бүтээхдээ Хүннү гүрний үеэс эх үүсгэлтэй монгол төрийн бэлгэдлийн уламжлал хийгээд эртний Энэтхэгээс үүдэл гаралтай хэмээдэг төрийн хос ёсны бэлгэдлийн уламжлалыг эвсүүлэн найрсуулж хэрэглэжээ.

Хуульд тусгагдсан байдлаар нь Монгол Улсын төрийн бэлгэдлийг дотор нь албан ёсны болон

албан бус гэж хоёр ангилж болохоор байна. Албан ёсны бэлгэдэлд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т хуульчилж өгсөн төрийн сүлд, төрийн далбаа, төрийн тамга гэсэн гурван бэлгэ тэмдэг орж буй бол албан бус бэлгэдэлд хэдий хуульчлан батлаагүй ч хэрэглэж байсан төрийн дуулал, хаан төрийн долоон эрдэнэ зэрэг бэлгэ тэмдэг орно.

Төрийн сүлдний тухайд Монгол Улсын шашин төрийг хослон баригч хаанаар өргөмжлөгдсөн наймдугаар Богд Жавзандамба хутагтын анхдугаар дүр, Өндөр гэгээн Г.Занабазарын зохиосон соёмбо бичгийн тэргүүн тэмдэг, титэм үсгийг сонгон хэрэглэжээ. Хожим мутрын тэмдгээ болгосон гэгддэг энэ тэмдгийг тэр бээр бүтээхдээ Монголын эртний сүлд болох нар, сар, галын дүрсийг оройд нь залж, монгол тамгануудын дүрсийг оролцуулан, эртний Энэтхэгийн бэлгэдлийн ёгт ном “Нанживандан” үсгэн хээнээс эх авч, тусгаар тогтносон Монгол Улсыг бэлгэдсэн нь ийн биелсэн байна. Монгол Улсын албан ёсны сүлд соёмбыг энэ цагаас анхдугаар Богд Жавзандамба хутагтын зохиосон тэмдэг, Богд хааны урд дүрийн сүлд төдий бус монгол төрийн бэлгэ тэмдэг гэх үзэл, итгэл үнэмшил улам батжин гүнзгийрчээ.

Төрийн далбааны тухайд хэдийгээр түүнийг байгуулах тухай баримтад олон улсын жишгийг харгалзан үзсэн нь тодорхой байгаа ч монгол төрийн түүхнээ Хүннү гүрний үеэс эхлээд таван өнгөт далбаа байгуулж байсан болон дундад зууны үед 44 Хөх Монголыг төлөөлсөн 44 хэлт хөх дарцаг хэрэглэж байсан түүхтэй тул уламжлал шинэчлэлийг хослуулсан гэж үзүүштэй байна. Монгол Улсын төрийн далбааны гурван хэл дээрх тарнийн үсэг, шаргал дэвсгэр дээрх мөргөлийн номын бичээс зэрэг нь шашныг, харин төв дундах таван махбодын өнгөт, хүрээтэй соёмбо нь төрийг тус тус бэлгэджээ. Монгол Улсын төрийн далбааг ийн шинээр байгуулснаас гадна цэргийн далбааг үйлдэж, нэгж бүрд тохируулсан далбаа шийтгэн олгож, нэршлийг нь тогтоон өгч, тугаас хиур хүртэлх далбааны зүйл дээр байрлуулах зүйлд, бичиг зэргийг хуульчлан зааж өгсөн нь онцлууштай хэрэг юм.

Төрийн тамгыг үйлдэхдээ эртнээс уламжлалтай дөрвөлжин хэлбэрийг барьж, Богд хааны төрийн тэргүүн тамгыг хашаар бүтээсэн нь, Хүннү гүрний хаад болон Их Монгол Улсын далай хааны хасбуу тамганы уламжлалыг дагасан хэрэг юм. Тамган дээрээ монголын гурван үсгээр “Төр шашныг хослон баригч наран гэрэлт Богд хааны тамга” хэмээх үгсийг сийлсний эхэнд төрийн сүлд, тэгээд соёмбо бичгээр найман мөр дэглэсэн нь анхдугаар Богдын зохиосон бичгийг хэрэглэснээс гадна түүний наймдугаар дүр хаан ширээнд заларч Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээсэн гэдгийг, тамганы төвд монгол бичгээр сийлсэн нь хуучин Манж Чингийн тамганд төвийн бичээсийг манжаар сийлж эзний эрхийг харуулдаг байсан ёсыг дагаж, монгол төрийн тамга гэдгийг, зүүнтээд дөрвөлжин бичгээр сийлсэн нь Богд хаан болбоос Их Юан Улсын хаан Хубилайн адил төрийн хос ёсоор засаг явуулагч хаан гэдгийг тус тус бэлгэджээ. Түүнээс гадна тамган дээрх хааны цол нь эртний Энэтхэгийн домогт, олноо өргөгдсөн Махасамади цол гэдгийг санууштай.

Мөн Богд хаанд хаш тамганаас гадна хэлбэр, дүрслэлийн хувьд адилхан хэмжээ ялимгүй том төрийн мөнгөн тамга бариулж, дарах бичгийн зэргэмжээс хамаарч, тэргүүн зэргийн хэргээс бусдад дарж байсан ба хааны төрийн хоёр тамганы бариулыг төр шашны хос ёсыг явуулагч хааны төрийн долоон эрдэнийн нэг болох чандмань дүрстэй урласан байдаг. Түүнчлэн хааны төрийн тамгануудаас бусад яамны тамгануудаас эхлэн бүх төрийн тамгыг нэгэн хэв, загварт оруулж, хэмжээг дөрвөлжин, төвд нь төрийн сүлд, хоёр хажуугаар нь монгол үсэг сийлж, бариулын чандманийн үзүүрийн тоо, тамганы хэмжээ, жин, эд зэргээр албаны зэрэглэлийг нь тогтоож өгчээ.

Монгол Улсын төрийн бэлгэдлийн онцлог бол шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт хааны эрх сүрийг өргөж, түүнээ бэлгэ тэмдэг бүрээр харуулахын зэрэгцээ үүндээ монгол төрийн уламжлал хийгээд эртний Энэтхэгийн төр, шашны бэлгэдлийг эвсүүлэн найрсуулж олон улсын жишгийг харгалзан тусгаж, ингэснээрээ тусгаар тогтносон, бүрэн эрхт улсын байдлыг илтгэн харуулж байсанд оршино.

Ном зүй

Архив

- Үндэсний Төв Архив, ф. 11, д. 1, х. н. 11.
Үндэсний Төв Архив, ф. АЗ, д. 1, х. н. 2
Үндэсний Төв Архив, ф. АЗ, д. 1, х. н. 3
Үндэсний Төв Архив, ф. АЗ, Д.1, х. н. 10.

Монгол хэлээр

- Бадарч, С ба Дугарсүрэн, Н. (2000). *Богд хааны он дарааллын товчоон*. Улаанбаатар: Хаадын сан.
- Батсайхан, О. (2014). *Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба. (Гурав дахь хэвлэл)*.
Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Батсайхан, О., Лонжид, З., Энхбат, Ч., Баатар, С., Амарсанаа, С. (2018). *Монголын түүх (1911-2017)*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Болдбаатар, Ж. (2003). *Түүх зулсан он жилүүдийн ойллого (II)*. Улаанбаатар: Монгол.
- Бямбасүрэн, Г ба Гантулга, Ц. (2012). *Монгол төрийн үүсэл, ёс ёслол, бэлгэдэл, хүндэтгэл, уламжлал (НТӨ 209-2011)*. Улаанбаатар: Адмон.
- Дамдинсүрэн, Ц. (2017). *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган VII: Монгол хэл судлал*.
Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Дулам, С. (2011). *Монгол бэлгэдэл зүй III: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*.
Улаанбаатар: Бит Пресс.
- Дулам, С. (2014). *Чингис хааны төрийн бэлгэдэл (Хоёр дахь хэвлэл)*. Улаанбаатар: Бит Пресс.
- Дэлгэржаргал, П ба Батсайхан, З. (2017). *Монголын эртний түүх: Хүннү*. Улаанбаатар: Соёмбо
принтинг.
- Дэндэв, Л. (2003). *XX зууны Монголын түүхийн эх сурвалж (Автономит Монгол Улсын үеийн
онцлог баримт бичгүүд)*. Улаанбаатар: Бит Пресс.
- Дэндэв, Л. (2006). *Монголын товч түүх*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Магсаржав, Н. (1994). *Монгол Улсын шинэ түүх*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн
Хэвлэл.
- Намнандорж, О. (1955). *Гайхамшигт бат бэх хааш чулуу*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Нямбуу, Х. (1979). *Монголын бэлгэдэл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Нямбуу, Х. (1990). *Өвөөгийн өгүүлсэн түүх*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Нямбуу, Х. (1992). *Хүндлэхийн дээд хөх Монголын төрийн ёслол, Чингисийн тахилга*. Улаанбаатар:
Алтан үсэгт.
- Нямбуу, Х. (1993). *Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын төрийн ёс, ёслол*. Улаанбаатар:
Шувуун саарал.
- Өлзийдолгор, Д. (1999). *Монгол Улсын төрийн тамга*. Улаанбаатар: Одсар системс.
- Ринчен, Б. (2015). *Монгол утга соёл судлал (Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган: VI боть)*.
Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Сандаг, Ш. (1971). *Монголын улс төрийн гадаад харилцаа (I)*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны
Академийн Хэвлэл, Улсын хэвлэлийн газар.
- Сүхбаатар, Г. (1980). *Монголчуудын эртний өвөг*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн
Хэвлэл.
- Түдэв, Л. (1996). *Үгсийн нууц уурхай*. Улаанбаатар: Сүхбаатар
- Түдэв, Л. (2002). *Монгол туг*. Улаанбаатар: Урлах-Эрдэм.

Гадаад хэлээр

Ринчен, Бямба. (1958). *Из нашего культурного наследия*. Улан-Батор: Центральный совет Общества монголо-советской дружбы.

Руденко, Сергей Иванович. (1962). *Культура Хуннов и Ноинулинские курганы*. Москва: Академии наук СССР.

Эмхэтгэл

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. (2018). Улаанбаатар: Соёмбо Принтинг.

Монгол Алтайн чулуун шастир. (2016). Улаанбаатар: “Чулуун шастир” судалгааны төвийн хэвлэл.

Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл: Баримт бичгийн эмхэтгэл (1900-1914). 1982. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар.

Диссертаци

Бямбасүрэн, Г. (2006). *Монгол Улсын төрийн ёс, бэлгэдэл, ёслол*. Түүхийн ухааны докторын диссертаци. Монгол Улсын Боловсролын Их Сургууль.

Эрдэм шинжлэгээний өгүүлэл

Дамдинсүрэн, Ц. (1944). Соёмбо үсэг. *Шинжлэх ухаан*, 7. 25-26.

Отгонбаатар, Р. (2005). Соёмбо сүлдийг бүтээдэг хувь хэмжээний тухай. *Соёмбын нууц ба синергетик*, 324-329.

Цэвээндорж, Д ба Батболд, Н. (2003). Монголчуудын өвөг дээдсийн эртний далбаа. *Цэргийн археологи*, Tomus III, Fasc. 3, 18-21.

Сонин, сэтгүүл

Жамбалдорж, С. (2006). Монгол төрийн бэлгэдлийн түүхэн учир холбогдол. *Зууны мэдээ*, тавдугаар сарын 26, № 126.

Ринчен, Б. (1970). Тэнгэрийн дуутай шөнө. *Цог*, 35-36.

Ринчен, Б. (1991). Соёнба тэмдэг бол Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын алдар сайхан билэг тэмдэг мөн. *Утга зохиол*, № 22.

Товчилсон нэр

БНМАУ – Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ХХГБХТЕЗШГ – Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр
Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар

Abstract

When the state symbolism of the Bogd Khanate of Mongolia was created, a dual state symbolism was adopted incorporating both Mongolian state symbolism originating from the era of the Hunnu Empire and state symbolism originating in ancient India.

The state symbols of the Bogd Khanate of Mongolia may be classified into two types by legal status, official and unofficial. Where the official symbolism included the three symbols of the state emblem, state flag, and state seal enacted in the “Mongolian Legal Rescript Enacted by Decree,” the unofficial symbolism included symbols like the national anthem and the Seven Imperial Treasures that were used despite not being legally enacted.

As for the specific features of the state symbolism of the Bogd Khanate, they consisted in raising the majesty and authority of the absolutist, theocratic khan, as shown by each symbol, as well as adopting ancient Indian state and religious symbolism and reflecting international norms, thereby asserting Mongolia’s status as an independent sovereign nation.

Keywords: Zanabazar, soyombo, state emblem, state flag, state seal

Зураг



Зураг 1. *Богд хаант Монгол Улсын төрийн сүлд*



Зураг 2. Нанживандан



Зураг 3. Богд хаант Монгол Улсын төрийн далбаа



Зураг 4. Богд хааны төрийн хааш тамга



Зураг 5. Богд хааны төрийн мөнгөн тамга



Зураг 6. Богд хааны шашны алтан тамга



Зураг 7. Богд хааны төрийн хааи тамганы бичээс



Зураг 8. Богд хааны төрийн мөнгөн тамганы бичээс



Зураг 9. Богд хааны шашны алтан тамганы бичээс